



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/21

Есөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажип, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хошой аварга, аварга малчин, хадланч, тариаланч, саальчин, аймгийн хөдөлмөрийн аваргын энгэрийн тэмдэг хийлгэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Тус ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, шаардагдах 7,623,000 (долоон сая зургаан зуун хорин гурван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
1 дүгээр сарын 18-ны өдрийн 4/2 дугаар
захирамжийн хавсралт

ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Аймгийн аварга малчин тэмдэг	400	9,000	3,600,000
2	Аймгийн Хошой аварга малчин тэмдэг	40	18,000	720,000
3	Аварга Саальчин	10	21,000	210,000
4	Аварга тариаланч	20	21,000	420,000
5	Аварга хадланч	20	21,000	420,000
6	Аймгийн хөдөлмөрийн аварга	100	15,600	1,560,000
7	Дүн	-	-	6,930,000
8	НӨАТ	-	-	693,000
	НИЙТ	490	-	7,623,000

__оОо__